



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ,
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2021 он

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ,
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2021.12.15.

Хуурч

Д/д	Шийдвэрийн утга, огноо, дугаар	Хариуцах албан тушаалтан	Заалт	Хэрэгжилт	Хувь	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ						
1	Татварын багц хуулийн хэрэгжилт	Татварын байцаагч	<p>-2-р бүлэг 10-р зүйл хөнгөлөлт, чөлөөт</p> <p>- 6-р бүлэг 25-р зүйл татвар төлөгчийн бүртгэл</p> <p>6-р бүлэг 28-р зүйл татвар ногдуулалт, төлөлт</p> <p>6-р зүйл 29-р зүйл татварын тайлан хүлээн авах</p> <p>9-р бүлэг 41-р зүйл татварын хяналт шалгалт</p> <p>11-р бүлэг 4-р зүйл татварын буцаан олгох,суутган тооцох</p> <p>11-р бүлэг 51, 52-р зүйл татварын нэхэмжлэх, өр төлүүлэх дараалал</p>	<p>ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтөд 1, аж ахуйн нэгж, орон сууц болон оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлт чөлөөлөлтөд 43 иргэн хамрагдсан.</p> <p>Шинээр 3 ААН-г бүртгэж төрлийн бүртгэлд бүртгэсэн.</p> <p>Улсын төсөвт 190,575.4 мянган төгрөг оруулахаас 166,240.2 мянган төгрөг буюу 87.2 хувь</p> <p>Аймгийн төсөвт 398,350.0 мянган төгрөг оруулахаас 438,529.6 мянган төгрөг буюу 110.1 хувь</p> <p>Сумын төсөвт 306,250.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 332,296.0 мянган төгрөг буюу 108.5 хувь</p> <p>Нийт 895,175.4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 937,065.8 мянган төгрөг буюу 104.6 хувиар биелүүллээ.</p> <p>2021 оны 1,2,3-р улирлын тайланг хүлээн авахад: Үүнд: ТТ-11 тайлан 100%, ТТ -12 тайлан 100%, ТТ-03 тайлангийн ирцийг 100% хүлээн авч ажилласан.</p> <p>Эхний хагас жилийн байдлаар татварын хяналт шалгалт 5 ААН-д хийгдэж байна.</p> <p>5 ААН хүсэлт ирүүлсний дагуу суутган тооцоолол хийсэн.Татварын өр төлүүлэх нэхэмжлэх хүргүүлж 22 ААН-д шат дараалсан арга хэмжээ авсан.</p>	100%	

2	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай	Хүнс ЖДҮ, хоршоо хариуцсан мэргэжилтэн		Сумын засаг даргын баталсан удирдамжийн дагуу 4 удаа хяналт шалгалт хийж, нийт давхардсан тоогоор 16 аж ахуйн нэгж, 12 иргэн хамрагдсан. Шалгалтын явцад нийт 15 зөрчил илрүүлж 10 зөрчлийг арилгуулж, зөрчилтэй 6 ш бүтээгдэхүүн, хадгалах хугацаа нь дууссан 47 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулж байсныг илрүүлж газар дээр нь устгаж, лангуунаас татуулж буцаалт хийлгүүлэв. Худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны салбарт ажилладаг 60 иргэдээс эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 41 иргэн бүрэн хамрагдсан байна. Үлдсэн 19 иргэн хамрагдахаар төлөвлөн ажиллаж байна.	100%	
3	Статистикийн тухай хууль	Төрийн сангийн мэргэжилтэн, статистикч	2-р бүлэг 4, 5, 6 - р зүйл 5-р бүлэг 20, 21-р зүйл	Статистикийн тухай хуулийг өдөр бүр хэрэгжүүлэн холбогдох мэдээ тайлан, тооллого судалгаануудыг цаг хугацаанд нь гаргаж, мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн программд шивж, файлаар болон цаасаар аймгийн статистикийн хэлтэст хүргүүлэн, хэрэглэгчдийг мэдээллээр ханган ажиллаж байна.	100 %	
4	Төсвийн тухай хууль	Санхүү албаны дарга	Хуулийг хэрэгжүүлэх	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнаж, төсвийг сар, улирлын хуваарилалтандаа багтаан зарцуулж, өр авлага үүсгэхгүй бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100 %	
5	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай	Засаг даргын орлогч, Санхүү албаны дарга	Хуулийг хэрэгжүүлэх	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэн, төсөвт байгууллагуудын эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад хөндлөнгийн хяналт тавьж эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулан үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг ТБОНӨЭХ бүртгэлийн /Тө-1, Тө-2, Тө-3, Тө-15/ маягтуудыг төсөвт байгууллага бүрээр гарган аймгийн ОНӨГ азарт хүргүүлэн ажиллаж байна.	100%	

6	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль	Хөдөлмөр эрхлэлт, халамж хариуцан мэргэжилтэн		<p>Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль болон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар ШАБ 40 иргэн, Зуучлал -35, чиг баримжаа зөвөлгөө өгөх үйлчилгээнд 20 иргэнийг бүртгэж ажилласан байна. Цар тахлын үед аж ахуй эрхлэх үйл ажиллагааг сэргээх төсөл хөтөлбөрийн хүрээнд: Малжуулах төсөл хөтөлбөрт 2 иргэн 9 сая төгрөгөөр 16 тоо толгой мал худалдан аваад байна. Ажлын байрыг дэмжих эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 2 иргэн авто засвараар 8 сая төгрөг авч үйл ажиллагаагаа өргөтгөн ажиллаж байна.</p>	100%	
7	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль	Мал эмнэлгийн тасгийн дарга		<p>Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж байгаа ба Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын нэгдсэн групп, facebook хуудсанд зар тавьж, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй хамтран 3 багийн 350 гаруй малчин болон мал бүхий иргэдэд хуулийн талаарх мэдээллийг цахимаар болон биечлэн хүргэн мэрэгжил арга зүйн заавар өгч ажиллаж байна.</p> <p>Хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж 2021 оны 01 дүгээр сарын 19, 05 сарын 10-ны өдрийн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг удирдамжийн дагуу ажлын хэсэг 2 удаа хийсэн Худалдаа үйлчилгээ, аж ахуйн нэгж байгууллагуудаар Зөвлөмж зөвлөгөө, цагийн хуваарь, хүнсний аюулгүй байдал дээр хяналт тавьж ажиллав. Орлогч дарга Б.Ууганбаяр ахалж, гишүүд нь ХЧСХМэргэжилтэн Г.Сумъяасүрэн, Татварын байцаагч Т.Энхбат, Мал эмнэлгийн улсын байцаагч М.Алтаннавч, нарын бүрэлдэхүүний хяналт шалгалт хийж зөвлөмж зөвлөгөө өгч ажиллаа. Худалдаа үйлчилгээ эрхэлж буй 6 газрын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн.</p> <p>Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ болон хаяг шошго, хугацаанд хяналт тавихад зөрчил илрээгүй хэвийн байсан.</p>	100%	

8	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	БОХУБ, байгаль хамгаал агч	Хуулийг хэрэгжүүлэх	2021 оны 03-р сарын 20-оос 06 сарын 10-ны хооронд ойд үйл ажиллагаа явуулахыг хориглосон үед 1-р багийн нутаг дэвсгэрт бургастай даваа, 2-р багийн Хуурчийн аманд хууль бус мод бэлтгэсэн байсныг илрүүлж цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.	70%	
9	Соёлын тухай хууль	Соёлын төвийн эрхлэгч	3-р бүлэг 6 зүйлийн 4 зааснаар	Соёлын төв нь орон нутгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх, иргэдийн авьяас чадварыг хөгжүүлэх, соёлын биет болон биет бус өв, ТСҮХДЗүйлсийг сурталчлан таниулан өвлүүлэх, хамгаалах тэднийг соён гэгээрүүлж хүмүүжил олгох үйлчилгээг эрхлэн явуулдаг.	100%	
10	Соёлын өвийн тухай хууль	ОНСТ-ын ажилчин	4-р бүлэг 12 зүйл 12.2	Соёлын төвийн бүртгэл мэдээллийн санд 175 дэсийн 351ш биет өв, 243 ТСҮХДЗүйлс, 45 биет бус өв тээгчийн бүртгэл мэдээлэл байдаг.	100%	
11	Эрүүл Мэндийн тухай хууль	ЭМТ-ийн дарга	3-р бүлгийн 13-р зүйл, 16-р зүйлийн 16.7, 20-р зүйл, 21-р зүйл,	Сумын хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар үзүүлж байна.	100%	
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ						
1	2010.01.14 №63	БОАХ мэргэжилтэн А.Ариун цэцэг	Мод тарих үндэсний өдөр зарлах тухай	Аймгийн Засаг даргын 2021 оны А/69 тоот захирамж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 34 тоот тогтоолоор батлагдсан "Ногоон сум" арга хэмжээ, сумын Засаг даргын "Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах тухай" А/51 тоот захирамжийн хүрээнд "Бүтээлийн нуур" ХХК, "Шинэ бадрах" ХХК-ууд нийгмийн хариуцлагын хүрээнд сумын төвийн хатуу хучилттай зам дагуу 0.7 га газарт шинээр ногоон зурвас байгуулах хамгаалалтын хашаа барьж Засаг даргын Тамгын газрын албан хаагчид уг хашаанд 250 ширхэг, "Атар-60" цогцолборын ногоон байгууламжид 65 ширхэг, Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн ангийн хашаанд 60 ширхэг нийт 375 ширхэг нарс модыг аж ахуй нэгж байгууллага, сумын иргэдтэй хамтран тарьсан. Аяны хүрээнд аж ахуй нэгж байгууллага, айл өрхүүд нийт 2800 ширхэг мод, бут сөөг тарьж гаднах тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлсэн.	100%	

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ						
1	2021.02.10 №27	Д.Алтан зориг	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай	Засгийн газрын тогтоолын дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин хавсралтаар ирүүлсэн байгууллагуудыг нээлттэй ажиллуулсан.	100%	
2	2021.04.23 №104	Д.Алтан зориг	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай	Засгийн газрын тогтоолын дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгасантай холбогдуулан пост, эргүүл, жижүүрийн ажил үүргийг томилгоожуулж үүрэгжүүлж ажиллаа.	100%	
3	2021.05.05 №115	Д.Алтан зориг	Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай	Захирамжийн хүрээнд заагдсан хугацааны дагуу сум руу орох гарах хөдөлгөөнд хязгаарлалт тогтоож, зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг хэвийн явуулж, мөн 18 граудусаас дээш агууламжтай согтууруулах ундааны зүйлсийг худалдах түүгээр үйлчлэхийг хориглосон.	100%	
4	2021.05.19 №152	Д.Алтан зориг	Түр журам батлах тухай	2022 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдвар /ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэн сонгуулийн санал авах байранд сонгогчоос санал авах үед халдвараас сэргийлэх үйл ажиллагааг сонгуулийн хэсгийн хорооны бүрэлдэхүүн, иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн даамал, үйлчлэгч, ажиглагч, цагдаа, эрүүл мэнд, нутгийн захиргааны байгууллагын алба хаагч нар хамтран зохион байгуулж ажилласан. Мөн халдвараас сэргийлэх үйл ажиллагааг бүрэн авч ажилласан.	100%	
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЛБАН ДААЛГАВАР						
1	2021.05.03 03	Д.Алтан зориг	Ковид-19-ийн цар тахлын тархалтыг хумих арга хэмжээг сайжруулах, халдвар хамгааллын дэглэм, ажлын хариуцлагыг өндөржүүлэх тухай	Гамшгаас хамгаалах шуурхай штабын үйл ажиллагааг сайжруулан, цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулан ажилласан. Иргэдийг дархлаажуулалтад бүрэн хамруулсан.	100%	

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГЫН ТУШААЛ						
1	2021.02.25 №20	Д.Алтан зориг	Түр журам, заавар батлах тухай	Түр журмын дагуу тусгаарлан ажиглах байрыг спорт цогцолборт 10 ортойгоор бий болгосон. Халдвар хамгааллын хувцас, нэг удаагийн бээлий, амны хаалт, улавч зэргийг байршуулж бэлтгэсэн.	100%	
2	2021.03.03 №22	Д.Алтан зориг	Шуурхай штабыг шинэчлэн байгуулах тухай	Шуурхай штабыг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр шинэчлэн байгуулж штабт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын үндсэн ажил, үүргийг зохицуулж, цалин хөлс, урамшуулал, илүү цагийн нэмэгдэл хөлсийг хууль тогтоомжийн дагуу олгон ажиллаж байна.	100%	
АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ						
1	2021.03.10 №05	Д.Алтан зориг	Түр хугацаанд хөдөлгөөний хязгаарлалт тогтоох тухай	Улаанбаатар хот болон халдварын голомт бүхий орон нутгаас ирэх иргэдийн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг заагдсан хугацаанд хязгаарласан. Эрүүл бүс нутгаас болон аймаг дотроо зорчиж буй иргэдийг эрүүл мэндийн асуумж, нэвтрэх зөвшөөрлийг үндэслэн, бүртгэл судалгааг хийж нэвтрүүлсэн	100%	
2	2021.03.13 №06	Д.Алтан зориг	Хөдөлгөөний хязгаарлалт тогтоосон хугацааг сунгах тухай	Хөдөлгөөний хязгаарлалтыг сунган ажилласан. Иргэдийн /PCR/-ын 72 цагийн дотор өгсөн шинжилгээний хариуг үндэслэн мөн гэрийн ажиглалтад 7 хоног тусгаарлан ажилласан.	100%	
3	2021.03.23 №07	Д.Алтан зориг	Хөдөлгөөний хязгаарлалт тогтоох тухай	Хөдөлгөөний хязгаарлалтыг заагдсан хугацаанд тогтоосон. Халдварын голомт бүртгэгдсэн бүс нутгаас ирэх иргэдийн /PCR/-ын 72 цагийн хүчинтэй хариуг үндэслэн нэвтрүүлэн гэрийн ажиглалтанд 7 хоног тусгаарлан ажилласан.	100%	
4	2021.03.30 №09	Д.Алтан зориг	Шуурхай арга хэмжээ зохион байгуулах тухай	Бүдүүний гүүрний постонд иргэд, тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнд хяналт тавин ажиллаа.	100%	

5	2021.04.10 №11	Д.Алтан зориг	Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх	Уг тогтоолд тусгагдсан үйл ажиллагааны дагуу иргэдийн хүсэлтийг харгалзан аймгийн шуурхай штабын зөвшөөрлөөр нэвтрүүлсэн.	100%	
6	2021.04.10 №12	Х.Дашцэ рмаа	Коронавирусийн халдвар/Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, тархалтыг хумих үйл ажиллагааны зардлын зарцуулалтыг хянах тухай	Коронавирусийн халдвар/Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, тархалтыг хумих үйл ажиллагаанд иргэд, ААН, албан байгууллагаас ирүүлсэн хандив, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулж буй хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, сумын онцгой комиссын хурлын шийдвэрийн дагуу сумын онцгой комиссоор дамжуулан шийдвэрлэж байхыг төсөвт байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт танилцуулан зарцуулах хөрөнгийн судалгааг харьцуулсан үнийн саналтай хамт, авилга ашиг сонирхлын зөрчилгүй талаарх мэдэгдэл тайлбарыг санхүүгийн албаны дарга, засаг даргад тухай бүр танилцуулан, хянуулж, шийдвэрлүүлэн ажиллаж байна.	100%	
7	2021.04.24 №13	Д.Алтан зориг	Тогтоолын хугацаанд өөрчлөлт оруулах Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай	Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хяналтын цэгийн үйл ажиллагаа, алба хаагчдын бэлэн байдал, халдвар хамгааллын дэглэмийг чангатган ажилласан	100%	
8	2021.05.07 №14	Д.Алтан зориг	Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай	Уг тогтоолд тусгагдсан үйл ажиллагааны дагуу иргэдийн хүсэлтийг харгалзан аймгийн шуурхай штабын зөвшөөрлөөр нэвтрүүлсэн.	100%	
9	2021.05.12 №16	Д.Алтан зориг	Шуурхай штабын бүтэц, ажиллах чиг үүргийг тогтоох тухай	Шуурхай штабын бүрэлдэхүүнийг 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр шинэчлэн байгуулж Аймгийн онцгой комиссын 16 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	

10	2021.05.22 №17	Д.Алтан зориг	Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг цуцлах тухай	Хяналтын цэг болох бүдүүний гүүрний постын үйл ажиллагааг эрчимжүүлж, алба хаагчдын бэлэн байдал, халдвар хамгааллын дэглэмийг чангатган ажиллаа.	100%	
11	2021.06.17 №18	Д.Алтан зориг	Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс 06 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл 5 хоногийн хугацаанд сумаас орох, гарах хөдөлгөөнд түр хязгаарлалт тогтоосон. 18 градусаас дээш согтууруулах ундааг 12:00-18:00 цагийн хооронд худалдан борлуулах, тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас бусад төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн албан хаагчдын 30 хүртэлх хувийг ажлын байран дээр ажиллуулж ажлын байранд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн ажиллаж байна.	100%	
12	2021.07.01 №23	Д.Алтан зориг	Ковидын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	11-р сарын 20-ны өдрөөс 03-р сарын 31 хүртэлх хугацаанд Төрийн байгууллагуудын албан хаагчдыг/ 1 болон 2-р цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль/ эргүүл жижүүрийн ажилд татан оролцуулж ажилласан. 04-р сарын 01-ээс 06-р сарын 17-ны өдрийг хүртгэл ЗДТГ-ын алба хаагч нар дангаараа эргүүл жижүүрийг 12 цагаар тогтмол хийж байна. Суманд үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний байгууллагуудад халдвар хамгааллын дэглэмийг сахих, хүн хоорондын зай барих, амны хаалт тогтмол зүүх, гар ариутгах санамж зөвлөмжийг тогтмол өгч, хяналт тавин ажиллаж байна. Сумын онцгой комисс, соёлын төвтэй хамтран цагаан хоолой ашиглан зарлан мэдээллийг хүргэх мөн мэдээллийн самбар, Цагааннуур ЗДТГ, Цагааннуур сумын худалдаа үйлчилгээ, Цагааннуур зар мэдээ, Нуурын мэдээ зэрэг цахим хаягуудаар УОК, ЗГ, АОК-с ирүүлсэн шийдвэр, мэдээ мэдээллийг цаг тухайд нь иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна.	100%	

13	2021.10.27 № 32	А.Ганзориг	Коронавирусын халдварын хөнгөн хэлбэрийг гэрээр эмчлэх жишиг үнийг тогтоох тухай	2021 оны 08-12-р сарын хугацаанд гэрээр эмчлэгдсэн 143 иргэн эмчлэгдсэн. Уг тогтоолын дагуу 8,9,10-р сард гэрээр эмчлэгдсэн иргэдийн судалгааг гарган, зөрүүг тооцон нөхөн сэргээх эм олгохоор шийдвэрлэгдсэн ч ЭМЯ-ны сангаас санхүүжилт орж ирээгүйн улмаас одоогоор олгогдоогүй байна. Уг тогтоол гарснаас хойшхи хугацаанд хөнгөн хэлбэрээр гэрээр эмчлэгдэж байгаа иргэдэд 85.000 төгрөгийн эмийн багцыг олгож байна.	70%	
14	2021.11.13 № 35	М.Гоомарал	Хорио цээрийн дэглэм тогтоох тухай	Сумын Засаг даргын 11 сарын 30-ны өдрийн А/144 тоот захирамжаар сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд өөрийн суманд гаднаас мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хадалдан авах, тээвэрлэх, тууварлах, оруулж ирэх, амьтны шилжилт хөдөлгөөнийг тодорхойгүй хугацаанд хориглосон. Мөн үүний дагуу 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн Бүдүүний гүүрний хяналтын цэг дээр ажилтан албан хаагчийг томилон ажиллуулж урьдчилан сэргийлэх тарилгыг чанартай шуурхай зохион байгуулж байна.	100%	
15	2021.10.28 № 34	Д.Алтанзориг	ОК-ын ШШ-ын бүрэлдэхүүн бүтэц зохион байгуулалт ажиллах журмыг шинэчлэн байгуулах тухай	2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн Засаг даргын Захирамжаар сумын Онцгой комисс болон Гамшгаас хамгаалах шуурхай штаб, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулж ажиллах журмыг баталсан.	100%	
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР						

1	2021.08.16 01	Д.Алтан зориг	2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай	<p>2021 оны 08 дугаар сарын 18-ны өдөр 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг гарган батлуулж гүйцэтгэлийг ханган ажиллалаа. 09 дүгээр сарын 17-ний өдөр Сэлэнгэ энерго ОНӨААТҮГазар сумын дулаан халаалтын үйл ажиллагааг хүлээлгэн өгч, тус үйл ажиллагааг хариуцан ажиллах байгууллагыг сонгон шалгаруулалт явуулж Эл Си Би ХХК шалгаран гэрээ байгуулан өөрийн хөрөнгөөр нэг тогоог солин, нүүрсний нөөц бүрдүүлэн хэвийн ажиллаж байна.</p> <p>Сумын ундны цэвэр усны төв худагт урсгал засвар хийж шинээр нэг насос тавьж, түгээх 2 худагт ухаалаг систем суурьлуулан халаагуур байрлуулж, цагдаагийн кубоны цэвэр усны хоолойг сэргээн дулаалах ажлууд хийгдлээ.</p> <p>Сумын Тийрэг 3 дугаар багийн хоёрдугаар хэсэгт ДСЦТСХК-тай хамтран 04 шугамын тулгуур солих, мөн төвийн хэсгийн өндөр хүчдэлийн муудсан модон шонгуудыг бетон тулгуураар солих ажлыг хийж гүйцэтгэлээ.</p> <p>Малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүд нийт хадлан -14300 тн, ногоон тэжээл-1400 тн, дарш, хүнсний ногооны хаягдал-920 тн, хужир шүү-950 тн бэлтгэж, сумын аюулгүйн нөөцөд 60 тн өвс нөөцлөн аваад байна.</p>	100%	
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ						
1	2021.01.08 А/04	Д.Алтан зориг	Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай	Аймгийн Засаг даргын 2021 оны А/04 тоот захирамжийн дагуу цэргийн бүртгэлийн 01 сарын 11-25-ны өдрүүдэд зохион байгуулж 1-р зэргийн 647, 2-р зэргийн 1910 бэлтгэл үүрэгтэний дэлгэрэнгүй бүртгэлийг аймгийн Цэргийн штабт хүргүүлсэн.	100%	

2	2021.01.22 A/15	Д.Алтан зориг	Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай	“Бүх нийтийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг” зохион байгуулах тухай албан бичгийг 19 аж ахуй нэгжид танилцуулан гарын үсэг зуруулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг 1 дүгээр сарын 23-наас 24-ний өдрүүдэд зохион байгуулан нийт 5 байгууллага, 33 аж ахуй нэгж, худалдаа үйлчилгээний газрууд Эрүүл мэндийн төвтэй хамтран заавар зөвлөмжийн дагуу байгууллагын дотор хэсэгт чийгтэй цэвэрлэгээ хийж, дотор, гаднах нийт 28657 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.	100%	
3	2021.01.25 A/20	Д.Алтан зориг	Уралдаан зохион байгуулах тухай	“Монгол Улсын Зэвсэгт хүчин 100” гар зургийн уралдаанд сумын Ерөнхий боловсролын сургуулийн 5 сурагч бүтээлээ явуулснаас бага ангийн төрөлд 5в ангийн сурагч У.Хосбаяр хоёрдугаар байр, ахлах ангийн төрөлд 10а ангийн сурагч Д.Үрээхэй гуравдугаар байр эзэлсэн.	100%	
4	2021.01.27 A/01	Д.Алтан зориг	2021 оныг “Чанарыг эрхэмлэх жил” болгох тухай	Аймгийн зарласан жилийн хэрэгжилтийг хангах сумын төлөвлөгөөг боловсруулан сумын Засаг даргаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.	70%	
5	2021.03.25 A/59	Г.Сумъя асүрэн	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох тухай	Суманд согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 10 аж ахуйн нэгжийн бар 3, мини маркет 4, худалдааны төв 1, хүнсний дэлгүүр 2, худалдан борлуулдаг 13 аж ахуй нэгж иргэдэд 2021 оны 03 сарын 25-ны А/59 тоот захирамжийг Архи согтууруулах ундаагаар үйлчилдэг 10 газарт танилцуулж гарын үсэг зуруулсан.Аймгаас гаргасан цагийн хязгаарлалт болон архи согтууруулах ундааг худалдан борлуулахгүй байх захирамжийн хэрэгжилтэд Хүнс хариуцсан мэргэжилтэн Г.Сумъяасүрэн, Сумын цагдаагийн алба нар худалдаа эрхлэгчдэд танилцуулан гарын үсэг зуруулан хяналт тавьж ажиллаж байна.	100%	

6	2021.02.01 A/23	Б.Ууганб аяр	Эрх шилжүүлэх тухай	Одоогоор хэрэгжээгүй	-	Зураг төсвийн хөрөнгө шийдэгдэ эгүй
7	2021.03.16 A/68	Б.Ууганб аяр	Ажлын хэсэг байгуулах тухай	Аймгийн засаг даргын Захирамжийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажилласан.	30%	
8	2021.03.16 A/69	Б.Ууганб аяр	Ажлын хэсэг байгуулах тухай	Суманд Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/29 тоот захирамжаар “Ногоон сум”-“1000 нарс” хөтөлбөр, Аймгийн Засаг даргын захирамжаар зарласан “Тохижилт-Ногоон байгууламж аян”-ыг хэрэгжүүлж зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө гарган, олон нийтэд сурталчлан таниулж хамруулан амжилттай хэрэгжүүлж ажилласан.	100%	
9	2021.03.18 A/70	Д.Алтан зориг	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай	Захирамжийн хүрээнд 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд захирамжид тусгагдсан үйл ажиллагааг явуулахыг хориглосон. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдэд мэдээлэх арга хэмжээг авч ажилласан.2021оны 03 дугаар сарын 22-ны өдөр Засаг даргын захирамж гарган онцгой байдлын газарт мэдээг цаг тухайд нь өгч ажилласан.	100%	
10	2021.03.26 A/81	Д.Алтан зориг	СӨБ-ын сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай	03 дугаар сарын 29-ны өдрөөс 04 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл сургуулийн өмнөх боловсролын сургалтыг зайн хэлбэрт шилжүүлсэнтэй холбоотойгоор багш нар бүлгийн групп чатаар дамжуулан эцэг эх асран хамгаалагч нарт хүүхдийг болзошгүй эрсдэл, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлж ажилласан.	100%	

11	2021.04.16 №113	Д.Алтан зориг	Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай	2021 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлага цар тахлын улмаас тодорхойгүй хугацаагаар хойшилсон.	-	
12	2021.04.16 №119	Д.Алтан зориг	Хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох тухай	Захирамжийн тогтоосон хугацаанд хичээл сургалтын үйл ажиллагааг зогсоосон.	100%	
13	2021.04.02 А/101	М.Алтан навч	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай	2021 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 9 нэр төрлийн вакцинжуулалтад нийт 127498 толгой мал, амьтан хамруулах төлөвлөсөн. Хагас жилийн байдлаар гүйцэтгэл Боом-64%, Шөвөг яр-100%, Цусан халдварт-92%, Тугалын иж балнад- 100%, Гахайн мялзан-50% хийгдээд байна.	100%	
14	2021.04.23 №128	Д.Алтан зориг	Захирамжуудын хугацаанд өөрчлөлт оруулж хугацааг сунгах тухай	Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгаж ажиллалаа.	100%	
15	2021.04.27 А/129	Ч.Алтан хуяг	Ажлын хэсэг байгуулах тухай	Малд үзлэг ангилалт хийх сумын засаг даргын захирамж гаргуулан 05-р сарын 15-наас 06-р сарын 09 хүртэл ангилалт үзлэгийг явуулан, мэдээллийг цуглуулж, мэдээлэл болосруулалт хийгдэж байна. Ноолуурын ашиг шимийн дундаж тодорхойлох зорилгоор 16 малчин өрхийн 11 борлон, 8 эм ямаа, 7 эр ямаанд хяналтын самналт хийж үзэхэд бохир жингээр борлон 486 грамм, эм ямаа 410 грамм, эр ямаа 530 грамм байв. Хогт хольц, хялгаснаас цэвэрлэж дахин жигнэсэн дундаж нь борлон 236 грамм, эм ямаа 200 грамм, эр ямаа 265 грамм байв.	100%	

16	2021.04.27 A/131	Д.Алтан зориг	Үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах арга хэмжээний талаар	Төрийн үйлчилгээний оператор томилгоожуулаагүй. Төрийн захиргаа хууль эрх зүйн ажилтан иргэдэд шаардлагатай лавлагаа мэдээллийг гарган өгч үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. 7 дугаар сард төрийн үйлчилгээний оператор томилгоожуулж ажиллуулахаар төлөвлөж байна.	30%	
17	2021.04.27 A/130	Ч.Алтан хуяг	Аян зохион байгуулах тухай	Ээмэгжүүлэх санхүүжилт шийдэгдээгүй учраас малчдын өөрсдийн хөрөнгөөр санхүүжигдсэн тул ээмэгжүүлэх малын 70% хамрагдсан.	70%	
18	2021.04.30 A/135	Ч.Алтан хуяг	Мал сүрэгт үзлэг ангилалт хийх тухай	2021 оны хаврын ангилалт үзлэг, ашиг шим тодорхойлох, ээмэгжүүлэх ажлыг эхлүүлж, 17 өрхийн 2600 хонинд ангийн болон хувьсын ангилалт, 860 хурганд үзлэг хийж, нийт 892 хонийг ээмэгжүүлэн бүртгэлжүүлэв. 1 малчны 86 үхэрт хаврын ашиг шим тодорхойлж, ээмэгжүүлэв. Намрын ангилалт, үзлэг цар тахлын нөхцлөөс шалтгаалан хийгдээгүй.	70%	
19	2021.05.05 A/138	Б.Ууганб аяр	Бүх нийтээр мод тарих аянийг зохион байгуулах тухай	Сумын Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/51 тоот захирамжаар “Бүх нийтээр мод тарих ажил”-ыг 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж 15 ААН, байгууллага, 35 иргэд хамрагдаж ажилласан. Энэ хүрээнд нийт 2 ойн мэргэжлийн байгууллагатай нийгмийн хариуцлагын хүрээнд гэрээ байгуулан шинээр ойн зурвас байгуулан 750 нарс, сумын хэмжээнд 150 нарс, 50 шинэс, Бусад төрлийн мод бут 500ш тарьсан.	100%	
20	2021.05.08 A/142	Д.Алтан зориг	Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай	2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 06 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хугацаанд 18 градусаас дээш агууламжтай согтууруулах ундааны зүйлсийг худалдах түүгээр үйлчилхийг хориглосон. Хавсралтаар ирүүлсэн үйл ажиллагааг хориглосон.	100%	

21	2021.05.10 A/146	Б.Ууганб аяр	Тариалалтын штаб байгуулах тухай	Сумын Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/57 тоот захирамжаар сумын "Тариалалтын штаб"-ыг 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, хуваарь гарган ажиллалаа.	100%	
22	2021.05.10 A/149	Б.Ууганб аяр	Үндэсний аюулгүй байдалын үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай	Холбогдох хууль, журмын хүрээнд иргэдийн аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. ҮАБЗ-ийн хагас жилийн тайлан мэдээг хугацаанд нь гаргаж ажилласан. 2021 оны Аймаг сумын хөрөнгө оруулалтаар "Ухаалаг худаг" 2 ш, Нэгдсэн хогийн цэгийг нэг мөр цэгцэлсэн, Нохой устгалын ажил, Тохижилт-ногоон байгууламжийн ажлууд хийгдээд байна.	70%	
23	2021.04.29 A/133	Б.Ууганб аяр	Өрхийн тариалан арга хэмжээ зохион байгуулах тухай	Өрхийн тариалалт арга хэмжээний хүрээнд ХХААЯамнаас 107 иргэнд 1921502,31 төгрөгийн хөнгөлөлттэй хүнсний үр олгосон. Аймгийн эмэгтэйчүүдийн холбооны дэмжлэгээр 3 өрхөд урт хугацаатай нөхцөлтэй зээлээр хүлэмж олгосон.	100%	
24	2021.05.27 A/165	Д.Алтан зориг	Захирамжийн холбогдох заалтыг хүчингүй болгох тухай	2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 4 дэх заалтыг хүчингүй болгосонтой холбоотойгоор 18 градусаас дээш согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчилхийг 2 021 оны 06 дугаар сарын 02-ноос зөвшөөрсөн.	100%	

25	2021.06.04 A/179	Д.Алтан зориг	Сарын аян зохион байгуулах тухай	Сарын аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу Ахмад настны идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих зорилгоор Иогийн видео хичээл, 6-9 насны хүүхдийн дунд гар зургийн уралдаан, 10-13 насны хүүхдүүдийн дунд шүлгийн уралдаан, “Алхах гүйх дугуй” арга хэмжээний хүрээнд иргэдийн дунд strava апп-ныг гар утсанд нь суулган 60 иргэний гар утсанд суулгаж өдөр бүрийн алхалтын маршрутыг аймгийн цахим хуудсанд тавьж ажиллаж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулагдсан цахим шатрын тэмцээнд 1 иргэнийг оролцуулсан.	70%	
26	2021.06.10 A/188	Б.Ууганб аяр	Малын хагас жилийн түүвэр судалгаа зохион байгуулах тухай	Малын хагас жилийн түүвэр судалгааг сонгогдсон 113 өрх, 7 ААН-ээс авахаар сумын засаг даргын А/61 тоот захирамжийн дагуу ажлын хэсэг томилогдон, 6 сарын 15-наас 6 сарын 20-ны хооронд халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулж, нэг удаагийн зориулалтын бээлий, амны хаалт, гар ариутгагч уусмал, хүн хүч техник хэрэгслээр бүрэн хангаж тооллогыг амжилттай зохион байгуулсан.	100 %	
27	2021.06.14 A/193	Д.Алтан зориг	Цар тахлаас урьдчилан сэргийлэх гамшгаас хамгаалах ажлыг эрчимжүүлэх тухай	2021 онд Засгийн газар, улсын онцгой комиссын тогтоол, аймгийн онцгой комиссын захирамж, тогтоолын дагуу Сумын Онцгой Комисс хуралдаж коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр тогтоол, шийдвэрийг цаг тухай бүрт нь гаргаж ажилласан.	100%	

28	2021.07.06 A/211	М.Алтан навч	Мал амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай	<p>Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний талаарх сэрэмжлүүлэг мэдээ зөвлөмж зөвлөгөөг 1,2,3 дугаар багийн нийт 100 өрхөөр “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж” гарын авлага бэлдэж тараалаа. Мөн шүлхий өвчний тархалт халдвараас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг сумын цахим хаягуудаар тогтмол хүргэж ажиллалаа. Албан тоотын дагуу халдвартай бүс нутгаас мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг тээвэрлэх, тууварлах, оруулж ирэхгүй байхыг иргэдэд анхааруулж, хяналт тавьж ажиллалаа.</p>	100%	
29	2021.08.13 A/238	Б.Ууганб аяр	Ургацын штаб байгуулах тухай	<p>Сумын засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/88 тоот захирамжаар 15 хүний бүрэлдэхүүнтэй Ургацын штаб байгуулагдан, ажлын төлөвлөгөө, хариуцлагатай жижүүрийн хуваарь гарган ажиллалаа. Энэ хүрээнд тариалалтын явцын мэдээг хугацаанд нь гаргах, цаг агаарын яаралтай мэдээ түгээх, ургац хураалтын ажлыг агро технологийн дагуу шуурхай зохион байгуулахад анхаарч, малчид тариаланчдын зөрчлийг зохицуулж мөн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг чанд мөрдүүлж ажиллалаа.</p> <p>08 дугаар сард Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын ажлын хэсэгтэй хамтран ургацын төлөв байдлыг тогтоосон. Улаан буудайн ургац 21,310 га талбайд тариалалт хийж 14,6 цн буюу 31,0 мянган тн, малын тэжээл 1514 га тариалж 10 цн буюу 15,5 мянган тн, рапс 12325 га тариалж 7,6 цн буюу 93,7 мянган тн ургац хураан авахаар тогтоосон. Нийт тариалан эрхлэгч ААН, хувиараа тариалан эрхлэгчдийн ургацын баланс гаргаж ургац тогтоолтыг 32 ААН, 36 иргэний талбайд хийн ажилласан.</p>	100%	

30	2021.09.14 A/72	Д.Алтан зориг	Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай	<p>2021 оны 2 дугаар ээлжийн хугацаат цэргийн албаны татлагад 45 иргэнийг хамруулснаас 12 иргэн эрүүл мэндээр тэнцэж цэргийн алба хааж байна.</p> <p>Цэргийн насны бүртгэлд байгаа иргэн шилжилт хөдөлгөөн хийлгэх хүсэлт гаргахад аймгийн ЦШ-т бүртгүүлж хасалт хийлгэх зөвлөмж өгч ажиллаж байна. 2021 онд цэргийн насны 2 иргэн шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.</p> <p>Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах 15 иргэнд багийн Засаг дарга нараар дамжуулан мэдэгдэл өгсөн ба 2 иргэн мөнгөн төлбөрөө төлсөн байна.</p>	100%	
31	2021.11.25 A/360	Б.Ууганб аяр	Мал тэжээвэр амьтдын тооллого явуулах тухай	<p>Малын хагас жилийн түүвэр судалгааг сонгогдсон 113 өрх, 7 ААН-ээс авахаар сумын Засаг даргын А/61 тоот захирамжийн дагуу ажлын хэсэг томилогдон 6 дугаар сарын 15-ны өдрөөс 6 дугаар сарын 22-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан. Тооллогоор нийт 62608 мал тоологдсон.</p> <p>Мал тэжээвэр амьтад, хашаа худгийн 2021 оны улсын тооллого 12 дугаар сарын 07-17-ны хооронд зохион байгуулагдлаа. Үүнтэй холбогдуулан сумын Засаг даргын А/145 тоот захирамж гарч 25 ажлын хэсэг байгуулагдан сумын Оргих, Хуурч, Тийрэг багийн өрхүүдэд тооллого хийлээ. Урьдчилсан дүнгээр 100 өрхийн 1816 тэжээвэр амьтад, 770 өрх, 11 ААНБ-ын 188,082 толгой мал тоологдсон.</p>	100%	
32	2021.11.25 A/361	М.Алтан навч	Дархлаажуулалт хийх тухай	<p>2021 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 100 мянган тун вакциныг аймгийн МЭГ-аас татан авчраад 12 дугаар сарын 05-ны өдрөөс малын эмч нартай 5 ажлын хэсэг гарч, малчин, мал бүхий өрхүүдээр вакцинжуулалт хийгдэж эхэлсэн. 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар дархлаажуулалт 81%-тай явагдаж байна.</p>	100%	

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГЫН ТУШААЛ						
1	2021.09.23 А/88	Д.Алтан зориг	Цэргийн ээлжит цэрэг татлага явуулах үеийн зарим арга хэмжээний тухай	2021 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлагад татагдсан иргэдийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан картыг сумын ЭМТ-ийн их эмч хариуцан авч 3 иргэнийг давтан шинжилгээнд хамруулж эмчиллээ. Цэргийн албаны татлагыг аймгийн Засаг даргын А/88 захирамж, сумын Засаг даргын А/119 тоот захирамжийн дагуу зохион байгуулж ажилласан. Цэргийн алба хаах насны залуучуудад зарлан дуудах хуудсыг багийн Засаг дарга нараар дамжуулан хүргэж сумын Эрүүл мэндийн төвд ковид -19 цар тахлын болон урьдчилсан шинжилгээг өгүүллээ.	100%	
АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ						
1	2021.02.24 № А/13	А.Ганзор иг	Коронавируст халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай	Коронавируст халдварын эсрэг вакцины 1-р тунгаар дархлаажуулах ажлыг зохион байгуулсан.	70%	
2	2021.05.27 № А/29	А.Ганзор иг	Коронавируст халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай	Коронавируст халдварын эсрэг вакцины 2-р тунгаар дархлаажуулах ажлыг зохион байгуулсан. Нийт 4764 хүн дархлаажуулалтад хамрагдсан.	70%	
3	2021.06.10 № А/30	А.Ганзор иг	Коронавируст халдварын эсрэг /Комирнэти BNT 162b2/ вакцинаар дархлаажуулах тухай	Жирэмсэн эх, хөхүүл эх, архаг хууч өвчтэй болон байнгын асаргаанд байдаг нийт 72 хүнийг дархлаажуулах ажлыг зохион байгуулах	70%	
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ						

1	2021.03.04 №25	Д.Амарс анаа	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай	2021-03-04 ны өдрийн 25 тоот тогтоолоор Дархан Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 12,85 км хатуу хучилттай авто замын төслийн хүрээнд Цагааннуур суманд зам тавих 4469185 м2 газрыг ашиглуулахаар ГЗБ-н төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсан. Уг тогтоолын дагуу сумын Засаг даргын 2021-03-10 өдрийн А/17 тоот захирамжаар 447 га газрыг 2 жилийн хугацаатайгаар ашиглуулахаар шийдвэрлэсэн.	100%	
2	2021.03.03 №16	М.Алтан навч	2021 оны Мал амьтны шимэгтгэгч өвчнөөс сэргийлэх	2021 оны шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллав. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 371282 толгой мал, амьтан хамруулахаар төлөвлөсөн. Гүйцэтгэл угаалга-20%, боловсруулалт бод-202%, боловсруулалт бог-50%, туулгалт бод-40%, бог-30%, нохойн туулгалт-50% цахим системд шивэгдсэн байна.	70%	
3	2021.03.11 №17	Б.Ууганб аяр	Багийн нэр баталгаажуулах тухай	Сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/37 тоот захирамжаар “Газар зүйн нэрийн салбар зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж, ажлын хэсэг Багуудын нэрийг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар баталгаажуулан холбогдох газарт хугацаанд нь уламжилсан.	100%	
4	2021.03.11 №28	Б.Ууганб аяр	Ажлын хэсэг байгуулах тухай	Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 28 тоот тогтоолоор баталсан “Үндэсний баяр наадам” зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан.	-	Ковид-19 цар тахлаас болж хэрэгжээг үй

5	2021.04.05 №34	Б.Ууганб аяр	“Ногоон сум” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай	Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 34-ний өдрийн 34 тоот тогтоолоор баталсан “Ногоон сум” арга хэмжээг ажлын хэсэг амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд “Жилд 1000 нарс”, иргэдийг мод тарихад арга зүйн зөвлөгөө өгч уриалан ИТХ, ЗДТГ, СДОанги, Төрийн болон төрийн бус байгууллага, ААН иргэдийг идэвхитэй хамруулж ажиллалаа. Энэ хүрээнд нийт 2 ойн мэргэжлийн байгууллагатай нийгмийн хариуцлагын хүрээнд гэрээ байгуулан шинээр ойн зурвас байгуулан 950 нарс, сумын хэмжээнд 150 шинэс, 22 төрлийн 2688 мод тарьсан тарьсан.	100%	
6	2021.04.29 №28	А.Ариун цэцэг	2021 онд бэлтгэх хэрэглээний болон түлээний модны хэмжээнд нэмэлт оруулах тухай	Үйлдвэрлэлийн огтлолоор Бүтээлийн нуур ХХК-нд 745м3, Цэвэрлэгээний огтлолоор-330м2 Үйлдвэрлэлийн огтлолоор Шинэ Бадрах ХХК-нд 745м3, Цэвэрлэгээний огтлолоор-330м2 тус тус хувиарласан.	100%	
7	2021.04.29 №26	Ч.Хонго рзул	Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зарцуулах чиглэлд зээлийн хэмжээг тогтоох тухай	ИТХ-ын 2021оны 04 дүгээр сарын 29 ны өдрийн 26 дугаар тогтоолоор сум хөгжүүлэх сангийн чиглэл: 1.Барилгын материал үйлдвэрлэл 2. Арьс шир боловсруулах үйлдвэрлэл 3. Цахилгаан хэрэгсэл, утас завсар үйлчилгээ чиглэлээр , зээлийн дээд хэмжээ 20,000,000 төг батлав.	100%	
8	2021.04.29 № 27	Д.Амарс анаа	2021 оны газар зохион байгууллатын төлөвлөгөөнд тодотгол оруулах тухай	2021 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 27 тоот тогтоолоор ГЗБ-н төлөвлөгөөнд тодотгол оруулж Сургуулийн өргөтгөл барих зориулалтаар 3300 м2,Худалдаа үйлчилгээний зориулалтаар 5000м2,Мод үржүүлгийн зориулалтаар 10000м2, Усалгаатай төмс хүнсний ногооны зориулалтаар 2 га газрыг нэмж оруулсан.	100%	

9	2021.05.29 №30	Ч.Хонгорзул	Сум хөгжүүлэх сангийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөн батлах тухай	Сум хөгжүүлэх сангийн орон тооны бус зөвлөлөөр 2021 он 04 сарын 29 –ны өдрийн 30 дугаар тогтоолоор зөвлөлийн даргаар Ц.Баянбаатар нарийн бичиг Ч.Хонгорзул Г.Гаттөмөр, Ц.Нандинчимэг М.Оюун-эрдэнэ, Д.Чимэгсанаа, М.Буянхишиг нарыг зөвлөлийн бус гишүүдээр батлав.	100%	
10	2021.05.24 №39	Ч.Хонгорзул	Сум хөгжүүлэх сангийн төсөл хүлээн авах, шалгаруулах хугацаа тогтоох тухай	Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлаар 2021 оны 05 сарын 24ны өдрийн 39 дугаар тогтоолоор сум хөгжүүлэх сангийн төсөл хүлээн авах хугацааг 2021 оны 06 дугаар сарын 11-21 хүртэл, шалгаруулах хугацаа 2021 оны 06 дугаарын 21-27ны хооронд явуулж дуусгахаар тогтоосон.	100%	
11	2021.10.15 34	Х.Дашцэрмаа	2021 оны тодотгосон төсөв батлах тухай	ИТХ-ын тогтоолын дагуу сумын засаг даргын А/120 тоот захирамжийн дагуу сумын 2021 оны тодотгосон төсвийн сар, улирлын хуваарилалтад өөрчлөлт оруулж, аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж, батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг олгон санхүүжүүлж байна.	100%	
12	2021.10.15 33	Т.Энхбат	2021 оны малын тоо толгойн албан татвар авах тухай	Малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө 119,985,200, гүйцэтгэл 73,425,780.00 буюу 61% байна. МТТАТ-н тайланг 706 малчин мал бүхий иргэдээс авахаас 706 буюу 100% авч дууссан.	100%	

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ,
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ,ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН НЭГТГЭЛ**

Цагааннуур сум

д/д	Шийдвэр	тоо	100	70	30	0	Хувь
1	МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ	11	10	1	0	0	97.2
2	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ	1	1	0	0	0	100
3	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ	4	4	0	0	0	100
4	УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЛБАН ДААЛГАВАР	1	1	0	0	0	100
5	УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГЫН ТУШААЛ	2	2	0	0	0	100
6	АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ	15	14	1	0	0	98
7	АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР	1	1	0	0	0	100
8	АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ	32	23	5	2	0	90.3
9	АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТУШААЛ	1	1	0	0	0	100
10	АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ	3	0	3	0	0	70
11	СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ	12	10	1	0	0	97.2
Нийт		83	67	11	2	0	95.7%

Тайлан гаргасан: ТГДҮТОГүйцэтгэгч

Д.Алтанзориг

Хянасан: Засаг дарга

Ц.Баянбаатар